



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 25 (502)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны долдугаар сарын 7

№25 (502)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

302.	Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 45	569
303.	Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 08 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 47	571
304.	Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай	Дугаар 48	572

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

305.	Мөнхбатын Даваажаргалд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай	Дугаар 142	572
------	--	------------	-----

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

306.	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 130	572
307.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 131	573
308.	Журам батлах тухай	Дугаар 133	577
309.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 136	578
310.	Мөнгөн шагнал олгох тухай	Дугаар 143	578
311.	Дүрэм шинэчлэн батлах тухай	Дугаар 146	579
312.	Журам батлах, шагналын хэмжээ тогтоох тухай	Дугаар 147	581
313.	Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай	Дугаар 150	586

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого батлах тухай

Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого"-ыг хэвсгалтаар баталсугай.

2. "Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого"-ыг баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай.

1/ донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан 2007 онд багтаан баталж, хэрэгжүүлэх;

2/ "Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого"-д тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусгах.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

Улсын Их Хурлын 2007 оны 45 дугаар
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ДОНОРЫН ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого"-ын зорилго нь эмчилгээний үр дүн сайтай, аюулгүй, чанарын баталгаатай цус, цусан бүтээгдэхүүнээр эрүүл мэндийн байгууллагыг тасралтгүй хангах, гамшгийн үеийн хүрэлцээтэй нөөцийг улсын хэмжээнд бүрдүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход оршино.

1.2. Донорын цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хангамжийн асуудал нь төрийн анхаарал, ивээлд байна.

1.3. Энэхүү бодлогын баримт бичиг нь донорын цусны аюулгүй, найдвартай байдал, цус, цусан бүтээгдэхүүнээр хангах ажлын зохион байгуулалт, материаллаг нөхцөл бололцоо, техник технологийн хангамж, хүний нөөцийн чадамжийг олон улсын түвшинд хүргэж, 2015 он хүртэл хөгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлно.

Хоёр. Донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зорилт

2.1. Эрүүл мэндийн байгууллагыг аюулгүй, чанарын баталгаатай донорын цус, цусан бүтээгдэхүүнээр жигд тэгш, хүртээмжтэй бүрэн хангана.

2.2. Гамшгийн үед шаардагдах цус, цусан бүтээгдэхүүний найдвартай, аюулгүй, хүрэлцээтэй нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангана.

2.3. Сайн дураар, төлбөргүйгээр цусаа өгсөн донор нь цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй, найдвартай хангамжийн эх үндэс болдог тул донорын хөдөлгөөнийг олон улсын зарчимд нийцүүлэн өргөжүүлж, сургалт, сурталчилгааны ажилд эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэний оролцоог нэмэгдүүлнэ.

2.4. Донорын цус, цусан бүтээгдэхүүнийг шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

2.5. Энэхүү бодлогын баримт бичгийн 3.3.1-д заасан байгууллагууд донорын цусны хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллахыг төрөөс дэмжинэ.

Гурав. Донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зам

3.1. Мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг дараахь чиглэлээр боловсронгуй болгоно:

3.1.1. донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлын чиглэлээр төв, орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа цус сэлбэлт судлалын үндэсний төв гүйцэтгэх.

3.1.2. энэхүү бодлогын баримт бичгийн 3.1.1-д заасан төв дээр донорын цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, хангамжийн талаархи мэдээллийн улсын нэгдсэн сүлжээ бий болгох.

3.2. Донорын хөдөлгөөнийг өрнүүлэх чиглэлээр хүн амын дунд сургалт, сурталчилгааг дор дурдсанаар зохион байгуулна:

3.2.1. эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран хүн амын дунд донорын хөдөлгөөнийг өрнүүлэн, сурталчилж, донорын үйлсэд идэвхтэй оролцсон иргэнийг урамшуулах ажлыг өргөжүүлэх.

3.2.2. донорын хөдөлгөөнийг дэмжигч аймаг, нийслэл, дүүрэг, сум болон байгууллага, хамт олон үүсгэл санаачилгыг төрөөс бүх талаар дэмжих.

3.3. Дараахь арга замаар донорын цус, цусан бүтээгдэхүүнээр найдвартай хангах хүрэлцээтэй нөөц бүрдүүлнэ.

3.3.1. цус сэлбэлт судлалын үндэсний болон бүсийн аюулгүй, эмчилгээний төв, аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх цусны албадад зайлшгүй шаардлагатай

бүтээгдэхүүн бэлтгэх, шинжлэх, хадгалах нөхцөл, техник, технологийг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

3.3.2. байгалийн гамшиг, олныг хамарсан осол, өвчин гарсан үед чанарын баталгаатай цус, цусан бүтээгдэхүүнээр найдвартай хангах, хүрэлцээтэй нөөц бүрдүүлэх асуудлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Монголын улаан загалмай нийгэмлэгийн оролцоотойгоор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцах.

3.4. Донорын цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээг дараахь байдлаар төлөвшүүлнэ:

3.4.1. эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу эрүүл мэндийн байгууллага цус, цусан бүтээгдэхүүнийг хэрэглэх журам, стандарт, аргачлал боловсруулах;

3.4.2. донорын цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэх ажилбарын үе шат бүрт энэхүү бодлогын баримт бичгийн 3.4.1-д заасан журам, стандарт, аргачлалыг мөрдүүлэх;

3.4.3. стандарт, аргачлалын сургалтад цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэх ажилбарт оролцдог эмнэлгийн мэргэжилтнийг бүрэн хамруулах.

3.5. Энэхүү бодлогын баримт бичгийн 3.3.1-д заасан байгууллагад чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, тэдгээрийн бүтэц, үйл ажиллагаа, бүтээгдэхүүний стандартыг шинэчлэн, олон улсын түвшинд хүргэх замаар донорын цус, цусан бүтээгдэхүүний чанарын баталгааг хангана.

3.6. Хүний нөөцийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дор дурдсанаар зохион байгуулна:

3.6.1. энэхүү бодлогын баримт бичгийн 3.3.1-д заасан байгууллагад ажиллах мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3.6.2. анагаах ухааны чиглэлээр сургалт явуулдаг сургалтын байгууллагын төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараахь төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрт эмчилгээний цус сэлбэлт судлалын анхны мэдэгдэхүүний талаар тусгаж, мэргэжлийн байгууллагын хэрэгцээг харгалзан цус сэлбэлт судлалын мэргэшсэн ажилтнаар хангах;

3.6.3. эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага нь донорын цусны аюулгүй байдлыг хангах, цусны бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх, энэхүү бодлогын баримт бичгийн 3.3.1-д заасан байгууллагад шинэ техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр гадаад орны холбогдох байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 08 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн "Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална." гэсэн 32.2 дахь хэсэг, "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай" Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн

хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин тавдугаар зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2007 оны 7 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 12.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

даргаар сонгосугай.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1.Улсын Их Хурлын гишүүн Долоонжингийн Идэвхтэнг Улсын Их Хурлын дэд

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

Мөнхбатын Даваажаргалд Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Японы мэргэжлийн сумо бөхөөр онцгой амжилттай барилдан дээд зиндаанд дэвшиж, удаа дараа түрүүлэн "Их аварга" цолыг хүртэж, бөх хүний уужуу ухаан, ухан мэх, эрэмгий зориг, эрч хүч, бяр чадлын гайхамшигийг үзүүлэн төр, түмэн олноо баясгаж, Монгол Улсын нэр төрийг Япон даяар төдийгүй дэлхий дахинаа

алдаршуулж буй бахдам амжилтыг нь үнэлж Япон Улсын Мияагино дэвжээний бөх Мөнхбатын Даваажаргалд Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 05 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
1. "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2003 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 164 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 4.2-ын "бөхийн цолны эрэмбээр гаргасан жагсаалтын дагуу тулгаж, бусад даваанд цолны болон амжилтын эрэмбээр угтуул бөх нэр сонсон" гэснийг "бөхчүүдийг цолны болон амжилтын эрэмбээр тулгаж барилдуулах бөгөөд бусад даваанд дээрх эрэмбээр, дархан аварга цолтнууд цолны эрэмбээр" гэж, 8.2-ын "барилдааны шөвгийн 16-д үлдсэн" гэснийг "барилдаанд тав болон түүнээс дээш давж шөвгөрсөн" гэж, 8.3 болон мөн тогтоолын 4 дүгээр хавсралтын 5.4-ийн "дээж" гэснийг "сорьц" гэж тус тус өөрчилсүгэй.

"11.1. Улсын баяр наадамд айрагдсан бүх морийг сэргээшийн шинжилгээнд оруулна.

11.2. Сэргээшийн шинжилгээнд сорьц авах, хадгалах, шилжүүлэх ажлыг Зохион байгуулах хорооноос баталсан журмын дагуу салбар хороо, Монголын үндэсний олимпийн хороо хамтран зохион байгуулна.

11.3. Хурдан морины уралдаантай холбогдон гарсан маргааныг салбар хороо шийдвэрлэнэ.

11.4. Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Зохион байгуулах хороонд Зохион байгуулах хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд тус тус гомдол гаргаж болно".

2. "Дүрэм шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 119 дүгээр тогтоолын хавсралтын 11 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн хавсралтын 12 дахь хэсгийг хүчингүй болсонд төөцсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭЭ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАТБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 05 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх" хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж жил бүрийн I

улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Сангийн сайд Н.Баяртсайханд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

Н.БАЯРТСАЙХАН

Засгийн газрын 2007 оны 131 дүгээр тогтоолын хавсралт

"ГАДААД ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ЦАХИМ НЭГ ЦОНХ" ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Оршил

Дэлхий нийтэд гадаад худалдааны цар хүрээ улам өргөжин тэлэхийн зэрэгцээ гадаад худалдааг зохицуулах дүрэм, журмыг хялбарчлах, шат дамжлагыг цөөрүүлэх, бичиг баримтын уялдаа холбоог сайжруулах, ил тод байдлыг дээшлүүлэх, мэдээллийн солилцоог хурдан болгох шаардлага улам бүр нэмэгдэж байна. Гадаад худалдааг хөнгөвчлөх асуудал чухал шаардлагатай байгааг дэлхийн худалдааны байгууллагын удаа дараагийн чуулга уулзалтаар хэлэлцэн, энэ хүрээнд "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг дэлхийн 30 гаруй орон амжилттай хэрэгжүүлж ихээхэн үр өгөөжтэй болохыг харуулаад байна.

Монгол Улсад гадаад худалдааг хөнгөвчилснөөр гадаад худалдааны үйл ажиллагааны саад тотгорыг багасгах, бүс нутгийн болон дэлхийн зах зээлд өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, улмаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх таатай орчинг бүрдүүлж өгөх юм.

2. Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үзэл баримтлал

2.1. Гадаад худалдааны цахим нэг цонхны тухай ойлголт.

Гадаад худалдаа эрхлэгч нь экспорт, импорт, дамжин өнгөрүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан дүрэм, журам, стандартын шаардлагыг мөрдөхийн тулд олон тооны мэдээлэл, бичиг баримтыг эрх бүхий байгууллагуудад цахим болон цаасан маягтаар бүрдүүлж өгдөг. Эдгээр

давхардсан бичиг баримт, дагалдан гарах зардал нь хил, гааль, хяналтын зэрэг холбогдох байгууллага болон бизнесийн хүрээнийхэн (худалдаач, тээвэр, тээвэр зууч, гаалийн зууч гэх мэт)-д ихээхэн хүндрэл учруулдаг. Энэхүү хүндрэлтэй асуудлыг шийдэх нэг арга бол гадаад худалдаа, тээврийн үйл ажиллагаанд оролцогч талуудад стандартчилагдсан мэдээлэл, бичиг баримтыг нэгдсэн цахим орчинд төвлөрүүлэх "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ыг бий болгох явдал юм.

2.2. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг нэвтрүүлснээр гарах үр дүн.

Холбогдох байгууллагуудын үйл ажиллагаа, бичиг баримтын уялдаа холбоо сайжирч, үйл ажиллагааны давхардал арилан, үр ашиггүй зардал багасгах, мэдээлэл солилцоог сайжруулснаар эрсдэлийн менежмент боловсронгуй болж, ил тод байдал дээшлэх, авлигал буурах, татвар, хураамж, төлбөрийг шуурхай, найдвартай аргаар хураан авч орлого нэмэгдэнэ. Бизнес эрхлэгчид гадаад худалдаа хийхэд шаардагдах бичиг баримт, мэдээллийг нэг удаа, нэг цонг бүрдүүлэх боломжтой болж цаг болон зардал хэмнэж, мэдээлэл тодорхой болсноор бизнесийн эрсдэл багасч, хугацаа хожимдлыг багасгаснаар туншийн итгэлийг олох, Бизнесийн үйл ажиллагаагаа тогтворжуулан, бараа эргэлт хурдсах, ил тод байдал сайжирч, аливаа дарамт, шахалтад өртөх боломж буурч бизнесийн үйл ажиллагааны нийт зардал буурна.

3. Хөтөлбөрийн үндэслэл

3.1. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг нэвтрүүлэх шаардлага.

Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан судалгаанаас үзэхэд Монгол Улс 2005 оны байдлаар дэлхийн 180 орноос нийт экспортын хэмжээгээр 131, импортын хэмжээгээр 150 дугаар байранд орсон байна. Дэлхийн зах зээлд Монгол Улсын эзлэх жин бага ч, гадаад худалдааны цар хүрээ сүүлийн жилүүдэд ихээхэн хурдацтай тэлж, улс орны эдийн засагт оруулах хувь нэмэр нь жилээс жилд өсч байна. Манай улс 2006 он гэхэд дэлхийн 109 оронтой худалдаа хийж гадаад худалдааны нийт эргэлт 3 тэрбум америк долларт хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулахад экспорт 55.9, импорт 51.4 хувьтай тэнцэж байна. 2006 оны байдлаар 70 оронд бараа экспортолж, 98 орны бараа импортолсон байна. 2005 он гэхэд Монгол Улсад 32870 экспортын, 79860 импортын гаалийн бүрдүүлэлт хийгджээ. 2006 онд Дэлхийн банкнаас 175 орныг хамарсан "Бизнес хийх орчны судалгаа" хийснээс бизнесийг хөнгөвчлөх үзүүлэлтээр Монгол Улс 45 дугаар байр эзэлж бүсийн хэмжээнд үнэлсэн 10 үзүүлэлтээс 6 үзүүлэлтэд нь хөрш орнуудтайгаа харьцуулахад маш сайн үнэлгээ авчээ. Харин 4 үзүүлэлтээр доогуур үнэлгээ авснаас "хил дамжсан худалдаа" гэсэн үзүүлэлтээр 175 орноос 162 дугаар байрт орсон байна.

Манай орны далайд гарцгүй байршил, хүн амын тархай суурьшил, эдийн засгийн жижиг цар хүрээ, дэд бүтцийн сул хөгжил, үр ашгийг зохион байгуулалт зэрэг нь хувийн хэвшил хөгжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна. Гадаад худалдаанд тулгарч байгаа зохион байгуулалт, дэд бүтэц, хүний хүчин зүйлсээс хамааралтай хүндрэлийг цахим нэг цонхны үйлчилгээ гэх мэт худалдааг хөнгөвчлөх шинэлэг аргуудыг нэвтрүүлэх замаар шийдвэрлэх шаардлага гарч байна.

Засгийн газар сүүлийн жилүүдэд худалдааг хөнгөвчлөх, бизнесийг дэмжих зорилгоор эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тарифын болон тарифын бус хязгаарлалтыг тодорхойлох, гаалийн бүрдүүлэлт болон хяналт шалгалтын үйл ажиллагаанд орчин үеийн технологийн ололт амжилтыг ашиглах, тусгай зөвшөөрөл олгох болон бүртгэх шат дамжлагыг багасгах зорилгоор "нэг цэгийг үйлчилгээ"-ний зарчмыг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байгаа ч эрх бүхий байгууллагуудаас баталж гаргадаг төвөгтэй дүрэм, журам, олон шат дамжлага одоог хүртэл оршиж бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулсаар байна.

Хоёр, Хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагаа, хамрах хүрээ

4. Хөтөлбөрийн зорилго

4.1. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг нэвтрүүлэн Засгийн

газар, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад худалдааны үйл ажиллагаанд учирч байгаа саад тотгор, давхардлыг арилгаж, үргүй зардлыг багасгах замаар бизнесийг хөнгөвчлөх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

5. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа

Хөтөлбөрийн зорилгыг дор дурдсан зорилт, тэдгээрт хамаарах үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

5.1. Нэгдүгээр зорилт

"Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх" хөтөлбөрийг нийтэд тайлбарлан таниулах, боловсрол олгох олон талт ажил зохион байгуулах.

Энэ зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1.1. гадаад худалдааны цахим нэг цонхны тухай ойлголтыг олон нийтэд сурталчлах, боловсрол олгох мэдээлэл харилцааны стратегийг боловсруулах;

5.1.2. Нээлттэй Засаг болон бусад веб сайт, телевиз, радио, сонин зэрэг мэдээллийн хэрэгслээр дамжуулан гадаад худалдааны цахим нэг цонхны тухай мэдээ, материалыг түгээх, цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулах;

5.1.3. шийдвэр гаргах түвшний ажигтнуудад цахим нэг цонхны тухай мэдээлэл өгөх;

5.1.4. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны тухай ойлголт, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хэвлэл мэдээллийнхэнд зориулсан хэвлэлийн бага хурлуудыг зохион байгуулах.

5.2. Хоёрдугаар зорилт

"Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.

Энэ зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.2.1. гадаад худалдааны зохицуулалтын талаар одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журамд дүн шинжилгээ хийх, цахим нэг цонхыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн орчин бүрдүүлэх.

5.2.2. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйл ажиллагааг удирдан явуулах, улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий бие

даасан хуулийн этгээд байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх;

5.2.3. цахим зөвшөөрөл, гэрчилгээ, гарын үсэг, төлбөр, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг боловсруулж батлуулах.

5.3. Гуравдугаар зорилт

Оролцогч талуудын мэдээллийн технологийн дэд бүтцийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг нягтлан судлах.

Энэ зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.3.1. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны оролцогч талуудыг цахим сүлжээнд бүрэн холбоход шаардагдах техник, технологийн шаардлага, хэрэгцээг тодорхойлох;

5.3.2. Стандартчилал, хэмжил зүйн төв болон Улсын мэргэжлийн хяналтын газрын мэдээллийн технологийн дотоод дэд бүтцэд үнэлгээ хийх, шаардлагатай тоног төхөөрөмж, үйлдлийн систем, хэрэглээний программ хангамжийг тодорхойлох.

5.4. Дөрөвдүгээр зорилт

"Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбогдуулан техник, эдийн засгийн дүн шинжилгээ хийх.

Энэ зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1. оролцогч яам, агентлагаас гадаад худалдааны бичиг баримтад тавьж байгаа шаардлага, байгууллагын дотоод болон байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмыг судалж тэдгээрийн уялдааг хангах, хялбаршуулах хэрэгцээг тодорхойлох;

5.4.2. үндэсний стандартыг олон улсын стандарттай нийцүүлэх хэрэгцээ, шаардлагыг судлах;

5.4.3. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг удирдан явуулах улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийг байгуулахад шаардагдах хөрөнгийн хэрэгцээ, дотоод, гадаадын боломжит хөрөнгө оруулагчдыг судлах.

5.5. Тавдугаар зорилт

Улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хамтарсан хуулийн этгээдийн хэлбэр, бүтцийг

тогтоох, хөрөнгө оруулагчид, стратегийн түншийг сонгох.

Энэ зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.5.1. улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хамтарсан хуулийн этгээдийн дүрэм, бүтэц, хөрөнгө оруулагчид, стратегийн түнштэй хийх гэрээний загварын боломжит хувилбаруудыг судлах;

5.5.2. дотоод, гадаадын хувийн хөрөнгө оруулагч, стратегийн түншид зориулж хөрөнгө оруулалтын санал, нууцлалын гэрээ зэрэг баримт бичгийн төсөл боловсруулах, тэднийг шаардлагатай мэдээллээр хангах;

5.5.3. улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хамтарсан хуулийн этгээдийн хөрөнгө оруулагчид, стратегийн түншийг сонгох, хөрөнгийн хувь хэмжээг тогтоох;

5.5.4. улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийн хэлбэр, бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар оролцогч талууд, дотоод, гадаадын хөрөнгө оруулагч, гадаадын стратегийн түнштэй хамтран ажиллах.

5.6. Зургадугаар зорилт

Улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлэх.

Энэ зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.6.1. улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийн албан ёсны нээлтийг хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийх болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг боловсруулан гаргах;

5.6.2. улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагааг эхлүүлэх.

6. Хөтөлбөрийн хамрах хүрээ

6.1. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны хөтөлбөрт дараахь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хамрагдана.

6.1.1. төрийн байгууллага:

-санхүү, үйлдвэр худалдаа, байгаль орчин, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, зам, тээвэр, аялал жуулчлал болон хууль зүй, дотоод хэргийн

асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, татвар, гааль, мэргэжлийн хяналт, стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан Засгийн газрын агентлаг, тэдгээрийн орон нутаг дахь салбар, харьяа байгууллагууд, лабораториуд.

6.1.2. төрийн бус байгууллага:

-Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим.

6.1.3. аж ахуйн нэгж:

-экспорт, импорт, банк, тээвэр зуучлал, лабораторийн шинжилгээ, тээвэр болон гаалийн зууч, логистикийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд болон бусад.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, зарчим

7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

"Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх" хөтөлбөрийг 3 үе шаттай хэрэгжүүлнэ.

1 дүгээр үе шат: "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг байгуулах бэлтгэл ажил (2007 он). Энэ үе шатанд 1-4 дүгээр зорилт, түүнд хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2 дугаар үе шат: Улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийн хэлбэр, бүтцийг тогтоох (2008 оны 1-6 дугаар сар). Энэ үе шатанд 1, 5 дугаар зорилт, түүнд хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3 дугаар үе шат: Улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлэх (2008 оны 7 дугаар сар) Энэ үе шатанд 1, 6 дугаар зорилт, түүнд хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

8.1. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

8.1.1. улс төрийн хүсэл сонирхол (Засгийн газар, бизнес эрхлэгчид аль аль нь "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг хэрэгжүүлэх хүчтэй сонирхолтой байх);

8.1.2. мэдээлэл сурталчилгаа ("Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг хэрэгжүүлэх тухай сурталчилгааг хөтөлбөрийн бүх үе шатанд явуулж оролцогч талуудад хөтөлбөрийн зорилго, зорилт, чиглэл, явц бэрхшээлийн талаар мэдээлж байх);

8.1.3. эрх зүйн таатай орчин (эрх зүйн орчинг бүрдүүлэх нь "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг хэрэгжүүлэх үндсэн утгавар нөхцөл мөн);

8.1.4. олон улсын шилдэг туршлага, технологи, стандарт, зөвлөмж (бичиг баримт, мэдээллийн загварыг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн боловсруулах, туршлагаар батлагдсан технологи, загварыг сонгон авч хэрэглэх);

8.1.5. бизнесийн, бие даасан, хамтарсан компани ("Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг хэрэгжүүлэх хуулийн этгээд нь төрийн байгууллагуудын зохицуулалтыг хялбаршуулсан, улс төрийн нөлөөллөөс харьцангуй ангид, бие даасан байх нь амжилтад хүрэх гол хүчин зүйл гэдгийг олон улсын туршлага нотолж байгаа);

8.1.6. Засгийн газар болон хувийн хэвшлийн түншлэл (улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийг байгуулах замаар дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татан, цахим нэг цонхны хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх боломжийг нээх, одоо ашиглаж байгаа мэдээллийн технологийн дэд бүтцийг төрийн өмчийн оролцоо болгон ашиглах);

8.1.7. "Байгуул, ажиллуул, шилжүүл" нөхцөл (улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээд нь цахим нэг цонхны үйл ажиллагааг тодорхой хугацаанд үр дүнтэй, үр нөлөөтэй ажиллуулсны дараа Засгийн газарт хүлээлгэн өгөх, энэ нь цахим нэг цонхыг байгуулахад шаардагдах төсвийн ачааллыг багасгах, дэвшилтэт ноу-хау технологийг нэвтрүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх нөхцөл болно);

8.1.8. хэрэглэхэд хялбар байдал ("Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг ашиглах талаар хэрэглэгчдэд зориулсан ойлгомжтой заавар, зөвлөмжийг гаргах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, хэрэглэгчдэд туслах үйлчилгээг бий болгох).

Дөрөв. Үр дүн

9. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх" хөтөлбөрийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл, бэлтгэл ажил хангагдаж дараахь үр дүн гарна.

9.1. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээний талаар оролцогч талууд болон олон нийтийн ойлголт бий болж түүнийг хэрэглэх урьдчилсан нөхцөл бүрдэнэ.



9.2. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүй, зохион байгуулалтын орчин бүрдэж, хөрөнгө оруулагч, гадаад түншээ сонгосон байна.

9.3. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйл ажиллагааг удирдан явуулах бизнесийн, бие даасан, улсын болон хувийн хэвшлийн хамтарсан хуулийн этгээд байгуулагдана. Энэ нь цахим нэг цонхны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх,

боловсронгуй болгох, тогтворжуулах бүхий л ажлыг компани бие даан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

9.4. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг байгуулснаар оролцогч талууд нь мэдээлэл шууд солилцох, бичиг баримтыг нэг цэг дээр, нэг удаа бүрдүүлж өгөх, зөвшөөрөл, гэрчилгээг цахим байдлаар олгох, хяналтыг шууд хийх боломжтой болж цаасан дээрх худалдаанаас хил дамжсан цаасгүй худалдаанд шилжинэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 05 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.14-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах

зардлыг санхүүжүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД

М.СОНОМПИЛ

Засгийн газрын 2007 оны 133 дугаар тогтоолын хавсралт

НҮБ-ЫН ЭНХИЙГ САХИУЛАХ БОЛОН ОЛОН УЛСЫН БУСАД АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СЭТГЭЛ ЗҮЙ, БИЕ БЯЛДРЫГ НӨХӨН СЭРГЭЭХ, СУВИЛАХ ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг санхүүжүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Цэрэг, цагдаагийн албан хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг төсвөөс санхүүжүүлэх бөгөөд Батлан хамгаалахын сайдын жил бүрийн төсвийн багцад тусган хэрэгжүүлнэ.

1.3. Сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлын хэмжээг цэргийн эмч нарын комиссын дүгнэлтийг үндэслэн батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

1.4. НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүн, цэргийн албан хаагчийн ажиллагааны явцад олсон өвчин эмгэг, гэмтлийг эмчлэх зорилгоор үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг

эрүүл мэндийн даатгал болон эрүүл мэндийн тухай Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулна. Энэ тохиолдолд цэрэг, цагдаагийн албан хаагчийн өөрөө төлбөл зохих эмнэлгийн ор хоног, оношилгооны зардлыг энэхүү журмын 1.2-т заасан зардлаас гаргана.

Хоёр. Зардлын төрөл

2.1. Бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардал дараахь төрөлтэй байна:

2.1.1. Сэтгэл заслын сувилгааны зардал. НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцоод ирсэн цэргийн албан хаагчид сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, тайвшруулах, алжаал тайлахад шаардагдах зардлыг үүнд хамруулна.

2.1.2. Бие бялдрыг нөхөн сэргээх зардал. Цэргийн албан хаагчийн бие бялдрыг нөхөн сэргээх зорилгоор бүх төрлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сувилах, амраахад шаардагдах зардлыг үүнд хамааруулна.

2.2. Сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдах бие бүрэлдэхүүн:

-НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсон цэрэг, цагдаагийн албан хаагч;

-олон улсын бусад ажиллагаанд оролцсон цэрэг, цагдаагийн албан хаагч.

2.3. Энэ журмын 2.2-д заасан цэргийн албан хаагчийг сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлын аль төрөлд хамруулах, тэднийг амраах хугацаа, сувилах үйлчилгээний хэмжээг цэргийн эмч нарын комисс тогтооно.

Гурав. Зардлын хэмжээ

3.1. Энэхүү журмын 2.1.1, 2.1.2-т заасан зардлын хэмжээг улсын эмнэлэг, сувилал, амралтын газраар үйлчлүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын дундаж хэмжээг үндэслэнэ.

3.2. Хэрэв цэргийн албан хаагчид өндөр өртөгтэй нарийн мэргэшлийн оношилгоо, шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай бол цэргийн албан хаагчийг Зэвсэгт хүчний клиникийн төв госпиталийн

дэргэдэх цэргийн эмч нарын комиссын дүгнэлт гаргуулж зардлын хэмжээг тодорхойлно.

3.3. Нэг цэргийн албан хаагчид зарцуулах зардлын нийт хэмжээ нь тухайн цэргийн албан хаагчийн сүүлийн 3 сарын албан тушаалын дундаж цалингаас хэтрэхгүй байна. Зардлын нийт хэмжээнд өндөр өртөгтэй нарийн мэргэшлийн оношилгоо, шинжилгээний зардлыг оруулж тооцно.

Дөрөв. Зардлыг олгох

4.1. Бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг тухайн цэргийн албан хаагч нь энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцоод ирсэний дараа 3 сарын дотор багтаан батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас олгоно.

4.2. Бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх зардлыг амралт, сувилал, эмнэлгийн байгууллагад шууд шилжүүлнэ. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд уг зардлыг цэргийн албан хаагчид мөнгөн хэлбэрээр олгож болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

2007 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах

Финлянд Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД**

Ц.ДАВААДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Мөнгөн шагнал олгох тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

Монакогийн Вант Улсын Монте Карлод зохиогдсон олон улсын өсвөрийн циркчдийн "Premiere game" тэмцээнд оролцож мөнгөн цомоор шагнуулсан уран нугараач Н.Алтанцэцэг, Б.Уянга нарт 2.450.000 (хоёр сая дөрвөн зуун тавин мянган) төгрөг, БНХАУ-ын Ухань хотод зохиогдсон олон улсын циркчдийн уралдаанаас мөнгөн медаль хүртсэн уран нугараач Г.Доржханд, Б.Одгэрэл, Э.Оюун-Эрдэнэ нарт 2.450.000 (хоёр сая дөрвөн зуун тавин мянган) төгрөг, Франц Улсын Парис хотноо зохиогдсон М.Магены нэрэмжит өсвөрийн төгөлдөр хуурчдын уралдаанд 1 дүгээр байр эзэлсэн сурагч

Б.Бат-Эрдэнэ болон Д.Саран нарт тус бүр 3.850.000 (гурван сая найман зуун тавин мянган) төгрөг, мөн уралдааны 2 дугаар байр эзэлсэн сурагч Ж.Ариунзаяад 3.150.000 (гурван сая нэг зуун тавин мянган) төгрөг, 3 дугаар байр эзэлсэн сурагч С.Анхжаргалд 2.450.000 (хоёр сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийн мөнгөн шагнал олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ө.ЭНХГҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм шинэчлэн батлах тухай" Засгийн газрын

2005 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 95 дугаар тогтоолыг хүчингүй болсон тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2007 оны 146 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмээр Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл (цаашид "Үндэсний зөвлөл" гэнэ)-ийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Үндэсний зөвлөл нь шинжлэх ухаан, технологийн чиглэлээр төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлаар зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бүр байгууллага мөн.

1.3. Үндэсний зөвлөл үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.4. Үндэсний зөвлөл нь ажлаа Засгийн газарт жил бүр тайлагнана.

1.5. Үндэсний зөвлөл нь зохих журмын дагуу хийсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.6. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад тусган санхүүжүүлнэ.

Хоёр. Үндэсний зөвлөлийн зохион байгуулалт

2.1. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд Засгийн газар, шинжлэх ухааны академи, их сургуулиуд, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн төлөөллийг оролцуулна.

2.2. Үндэсний зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, орлогч дарга нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

2.3. Үндэсний зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн даргыг Үндэсний зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн шинжлэх

ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

2.4. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргаар эрдэм шинжилгээний байгууллагад 5-аас доошгүй, төрийн захиргааны албанд 3-аас доошгүй жил ажилласан хүнийг томилж ажиллуулна.

2.5. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь орон тооны албан хаагч байх бөгөөд түүний цалинг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны ерөнхий менежер тогтооно.

2.6. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.6.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.6.2. Яамдын шинжлэх ухаан, технологийн зөвлөлтэй хамтран ажиллаж, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах арга хэмжээ авах;

2.6.3. Үндэсний зөвлөлийн хурлын шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж дүн, явцыг Үндэсний зөвлөлд тайлагнах;

2.6.4. Үндэсний зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангаж хурлыг зохион байгуулах;

2.6.5. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тухайн жилийн тайланг гаргаж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.

2.7. Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж эрхэлнэ.

Гурав. Хэлэлцэх асуудал, зөвлөлийн бүрэн эрх

3.1. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.2-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.



3.2. Үндэсний зөвлөл нь дор дурдсан асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргана:

3.2.1. Гурван жил тутам Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн үнэлгээ, цаашдын чиг хандлагын талаархи илтгэл;

3.2.2. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх төрийн бодлого, тэргүүлэх чиглэл, мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслийн санал;

3.2.3. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүн;

3.2.4. яамдын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.2.5. Төрийн төв болон нутгийн захиргааны байгууллагын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүн, тайлан;

3.2.6. суурь болон хавсарга судалгаа, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэхэд зарцуулагдах санхүүжилтийн харьцааг тогтоох асуудал;

3.2.7. шинэ технологи нэвтрүүлэх, тэргүүний технологи нутагшуулах технологийн парк, инкубатор, тэргүүлэх зорилтын сүлжээ байгуулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;

3.2.8. улсын хэмжээгээр тухайн жилд хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр;

3.2.9. боловсрол, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх;

3.2.10. төрийн бус байгууллага, хуулийн этгээдээс хэрэгжүүлж байгаа шинжлэх ухаан, технологийн төслүүд, тэдгээрийн үр дүнг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.2.11. төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын захиалгаар хэрэгжүүлсэн шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлж байгаа байдал, эдийн засаг, нийгмийн үр нөлөө;

3.2.12. үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх бодлого, түүний үр дүн;

3.2.13. эрдэм шинжилгээ, судалгааны шинэ чиглэлийг хөгжүүлэх асуудал;

3.2.14. эрдэм шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож үйл ажиллагааны үр дүн, чанар, өгөөжийг дээштүүлэх;

3.2.15. Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагааны тайлан;

3.2.16. хууль, тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

3.3. Үндэсний зөвлөл хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дор дурдсан эрх эдэлнэ:

3.3.1. шинжлэх ухаан, технологийн асуудлаар яам, Засгийн газрын агентлаг, дээд боловсрол, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн газраас холбогдох мэдээллийг гаргуулан авах;

3.3.2. Үндэсний зөвлөлийн эрхлэх асуудлаар яамдын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дарга, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллагын удирдлагын илтгэл, сонсголыг хэлэлцэх;

3.3.3. шинжлэх ухаан, технологийн болон инновацийн хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд дүгнэлт өгөх ажлын хэсэг байгуулан ажиллуулах, тайланг хэлэлцэх.

Дөрөв. Үндэсний зөвлөлийн ажиллах журам

4.1. Үндэсний зөвлөлийн ажиллах үндсэн хэлбэр нь хурал байна.

4.2. Үндэсний зөвлөлийн ээлжит хурлыг улиралд 1 удаа хуралдуулна. Үндэсний зөвлөлийн ээлжит бус хурлыг үндэсний зөвлөлийн даргын шийдвэрээр зарлан хуралдуулж болно.

4.3. Үндэсний зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйг тооцно.

4.4. Үндэсний зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлогч дарга даргална.

4.5. Үндэсний зөвлөлийн хурлын материалыг ажлын дөрвөөс доошгүй өдрийн өмнө гишүүдэд тараасан байна.

4.6. Хурлаар хэлэлцэх зарим асуудлаар салбарын эрдэмтэн, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж санал, дүгнэлтийг нь сонгож болно.

4.7. Үндэсний зөвлөлийн хурлын шийдвэр нь олонхийн саналд үндэслэнэ. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэр гаргана.

4.8. Үндэсний зөвлөлийн хурлын тэмдэглэлд хурал даргалагч болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

4.9. Санхүүжилттэй холбоотой асуудлаар гарсан Үндэсний зөвлөлийн шийдвэр нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталгаажсан байна.

4.10. Үндэсний зөвлөлийн хурлын дэргийг Үндэсний зөвлөлийн орлогч дарга баталж, мөрдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Журам батлах, шагналын хэмжээ тогтоох тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн шагнал олгох журмыг хавсралтын ёсоор баталсугай.

2. "Байгаль, нийгмийн ухааны шагнал", "Технологийн дэвшлийн шагнал"-ыг дагалдах мөнгөний хэмжээг тус бүр 100.0 (нэг зуун) сая төгрөгөөр, шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагналд олгох өргөмжлөлийг бүтээх өртгийг 10.0 (арван) сая төгрөг байхаар тус тус тогтоосугай.

3. Шагналыг дагалдах мөнгө болон энгэрийн тэмдэг, үнэмлэх, шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагналд олгох өргөмжлөл бүтээх хөрөнгийг

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин нарт даалгасугай.

4. "Байгаль, нийгмийн ухааны шагнал", "Технологийн дэвшлийн шагнал"-ын тэмдэг, үнэмлэх, Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагналд олгох өргөмжлөлийн загварыг уралдаан зарлаж, сонгон шалгаруулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2007 оны 147 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22.1-д заасан "Байгаль, нийгмийн ухааны шагнал" болон "Технологийн дэвшлийн шагнал", "Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагнал" горлох бүтээлийг нэр дэвшүүлэх, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх, материал хүлээн авах, шалгаруулах, шагнал гардуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. "Байгаль, нийгмийн ухааны шагнал"-ыг жил бүр 2 хүртэл бүтээлд, "Технологийн дэвшлийн шагнал"-ыг 2 жил тутам 1 бүтээлд, "Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагнал"-ыг 2 жил тутам 1 бүтээлд Засгийн газрын шийдвэрээр олгоно.

Хоёр. Шагналд нэр дэвшүүлэх бүтээлд тавигдах шаардлага

2.1. "Байгаль, нийгмийн ухааны шагнал"-ыг байгаль, нийгмийн шинэ үзэгдэл, зүй тогтлыг тодорхойлж, шинжлэх ухааны нээлт хийсэн иргэн, судлаачдын хамтлагт олгох бөгөөд уг бүтээл нь дор дурдсан шаардлага хангасан байна:

2.1.1. зарчмын шинэ технологи, техник, багаж, тоног төхөөрөмж, материал, бодис бий болгох, ашиглах боломж бүрдүүлсэн, эсхүл урьд нь нээгдэж тайлбарлагдаагүй байгаль, нийгмийн шинэ үзэгдэл, зүй тогтлыг тодорхойлсон байх;

2.1.2. техник, технологийн хөгжилд шинэ чиглэл нээсэн буюу Патентын тухай хуулийн 3.1.1, 4.3-т заасан шинэ бүтээлийн түвшин агуулсан байх.

2.1.3. шинжлэх ухааны холбогдох салбарын гадаад, дотоодын эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн байх;

2.1.4. үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах замаар эдийн засаг, нийгэмд бодитой үр ашиг өгөх.

2.2. "Технологийн дэвшлийн шагнал"-ыг өндөр үр ашиг, ач холбогдол бүхий шинэ технологи, бүтээгдэхүүн, материал зохион бүтээж, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн ашигласан иргэн, байгууллагад олгоно. Уг бүтээл нь дор дурдсан шаардлага хангасан байна:

2.2.1. олон улсын техник, технологийн хөгжлийн тэргүүний түвшинг хангасан байх;

2.2.2. экологийн хувьд цэвэр, эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь амьдрал дээр нотлогдсон байх.

2.3. "Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагнал"-ыг Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаадын иргэн, байгууллагад олгох бөгөөд энэ шагналд дэвшүүлэхэд дор дурдсан шаардлага тавина:

2.3.1. Монгол Улсын иргэн, байгууллагад дэлхийн шинжлэх ухаан, технологийн тэргүүний болон өндөр технологийн ололтыг эзэмшүүлэх, шинжлэх ухааны нарийн мэргэшлийн боловсон хүчин бэлтгэхэд онцгой хувь нэмэр оруулсан;

2.3.2. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн гадаад харилцаа, хамтын

ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан;

2.3.3. Монгол Улсын эрдэм шинжилгээний байгууллагын сорилт туршилтын баазыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан.

2.4. Энэ журмын 2.2, 2.3-т заасан шагналд нэр дэвшүүлэх бүтээлийн үр дүн нь уг бүтээлийг шагналд дэвшүүлэхээс нэг жилээс доошгүй хугацааны өмнө үйлдвэрлэлд (практикт) нэвтэрч бодитой үр дүн өгсөн байна.

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх

3.1. "Шинжлэх ухаан, технологийн салбарын шагналд нэр дэвшүүлэх тухай зарыг тухайн жилийн 1 дүгээр сард багтаан шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэлэл, мэдээллийн хэрэгсэл, вэб сайтаар дамжуулан нийтэд зарлана.

3.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын шагналд дор дурдсан байгууллага нэр дэвшүүлэх эрх эдэлнэ:

3.2.1. Төрийн захиргааны төв байгууллага;

3.2.2. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар;

3.2.3. Шинжлэх ухааны академи;

3.2.4. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 12.2-т зааснаар улсын бүртгэлд бүртгүүлсэн эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөл;

3.2.5. өмчийн хэлбэрээс үл хамааран 50-иас дээш ажиллагчтай аж ахуйн нэгж, байгууллагын хамт олны хурал;

3.2.6. Монгол Улсаас гадаад оронд суугаа Элчин сайдын яам.

3.3. Хэд хэдэн байгууллага хамтарч шагналд нэр дэвшүүлж болно. Энэ тохиолдолд эдгээр байгууллагын аль нэг нь толгойлогч байгууллагын үүрэг гүйцэтгэнэ. Бусад нь хамтран нэр дэвшүүлэгч байна.

3.4. Төрийн шагнал болон түүнтэй дүйцэх шагнал авсан, эсхүл нэр дэвшүүлсэн бүтээлийг шинжлэх ухаан, технологийн шагналд давхардуулан нэр дэвшүүлэхгүй.

3.5. Шинжлэх ухаан, технологийн салбарын шагналд нэр дэвшүүлсэн, энэ журмын 4.7-д зааснаас бусад бүтээл, зохиогчдын талаархи мэдээлэл нийтэд нээлттэй байна. Бүтээлийг шагналд нэр дэвшүүлэхээр хэлэлцэхэд үр дүнг нь нэвтрүүлэн ашиглагч байгууллагуудын төлөөллийг заавал оролцуулсан байна.

3.6. Хамтын бүтээлийг нэр дэвшүүлэхэд зохиогчийн хамтлаг нь 5 хүнээс хэтрэхгүй байна. Зохиогчийн хамтлаг 5 хүнээс илүү байгаа тохиолдолд уг бүтээлийг бий болгоход гишүүн тус бүрийн оруулсан бодит хувь нэмэр, оролцоог байгууллагын эрдмийн зөвлөлийн хурал, эсхүл хамт олны хурлын нууц санал хураалтаар шийдвэрлэж шагналд нэр дэвшүүлэх зохиогчийг сонгоно. Эрдмийн зөвлөл (хамт олон)-ийн хурлыг

түүний бүрэлдэхүүний дөрөвний гурваас доошгүй нь оролцож, олонхийн санал авсан дарааллаар хамтлагийн гишүүнийг нэр дэвшүүлнэ.

3.7. Шагналд нэр дэвшүүлж байгаа бүтээлийг бий болгоход захиргааны буюу зохион байгуулалтын ажил эрхэлж байсан хүнийг зохиогчийн хамтлагийн бүрэлдэхүүнд оруулахгүй.

3.8. Хамтын бүтээлийн зохиогчдын бүрэлдэхүүн, оролцоог нэр дэвшигч бүхэн хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан байна.

3.9. Хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, гэрээний үндсэн дээр Монгол Улсын холбогдох байгууллагатай хамтран гүйцэтгэсэн бүтээл нь шагналд нэр дэвшиж байгаа бол уг бүтээлийн зохиогчийн хамтлагийн бүрэлдэхүүнд гадаадын иргэнийг оруулж болно.

3.10. "Технологийн дэвшлийн шагнал", "Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагнал"-д байгууллагыг нэр дэвшүүлэх бол тухайн байгууллагын хамт олны хурлаас гаргасан шийдвэрийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага нь шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаараа хэлэлцэн дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

3.11. Шагналд нэр дэвшүүлж байгаа бүтээлийн талаархи материалыг тухайн жилийн 6 дугаар сарын 30-ны дотор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлж бүртгүүлсэн байна.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх материалыг бүрдүүлэх

4.1. Дор дурдсан материалыг 2 хувь бүрдүүлж, энэ журмын 4.5-д заасан дарааллаар байрлуулан тус бүрийг хавтаслан энэхүү журмын 3.11-д заасан хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүлээлгэн өгч бүртгүүлсэн тохиолдолд бүтээлийг "Байгаль, нийгмийн ухааны шагнал", "Технологийн дэвшлийн шагнал"-д нэр дэвшүүлсэнд тооцно:

4.1.1. шагналд нэр дэвшүүлэх тухай албан бичиг (журмын 1 дүгээр хавсралт);

4.1.2. хэвлэн нийтлүүлэх зөвшөөрлийн бичиг. Энэхүү зөвшөөрлийн бичгийг уг бүтээлийг шагналд дэвшүүлж байгаа байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр үйлдэж, тухайн байгууллагын дарга (захирал) гарын үсэг зурж, тамга (тэмдэг) дарж, огноо, дугаар тавьсан байна. Зөвшөөрлийн бичигт нэр дэвшүүлж байгаа бүтээлийн нэр, агуулга, зохиогчдын овог, нэр, тэдгээрийн албан тушаал, уг бүтээлийг хэвлэлд нийлэх тухай тусгана;

4.1.3. шагналд нэр дэвшүүлсэн байгууллагын эрдмийн зөвлөл (хамт олон)-ийн хурлын тэмдэглэл (журмын 2 дугаар хавсралт);

4.1.4. тухайн бүтээлд зохиогчдын оруулсан бодит хувь нэмрийн тухай тодорхойлолт. Үүнийг зохиогчдын хамтлагийн гишүүн, бүрээр гаргаж, зохиогчийн овог, нэр, одоогийн болон тухайн ажлыг гүйцэтгэх үед эрхэлж байсан ажил, албан тушаал, эрдмийн зэрэг, цол, бүтээлд оруулсан

хувь нэмрийг тусгана. Нэг зохиогчтой бүтээлийг дэвшүүлсэн бол зохиогчийн хувь нэмрийн тодорхойлолт шаардлагагүй;

4.1.5. зохиогчдын тухай танилцуулга. Нэр дэвшүүлж байгаа зохиогчдын тухай танилцуулгыг хамтлагийн гишүүн тус бүрээр, тэдгээрийн ажиллаж байгаа байгууллагын хэвлэмэл хуудсан дээр үйлдэж, нэр дэвшигчийн гарын үсгийг зуруулж, байгууллагын удирдах албан тушаалтан батламжилсан байна. Энэхүү танилцуулгад дор дурдсан мэдээллийг заавал тусгана:

4.1.5.1. овог, нэр (иргэний үнэмлэхтэй тохирч байх шаардлагатай), төрсөн он, сар, өдөр;

4.1.5.2. иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг;

4.1.5.3. ажиллаж байгаа байгууллагын нэр (байгууллагын нэрийг товчлохгүй);

4.1.5.4. эрхэлж байгаа ажил, албан тушаал;

4.1.5.5. эрдмийн зэрэг, цол;

4.1.5.6. алдар цол, шагнал (хэдийд ямар шагнал авсан);

4.1.5.7. тухайн байгууллагын шуудангийн хаяг, утасны дугаар;

4.1.5.8. гэрийн хаяг, утасны дугаар;

4.1.5.9. зохиогчийн 4х6 хэмжээний 2 хувь зураг (сүүлийн 6 сарын дотор авахуулсан).

Тайлбар: Шагналд нэр дэвшигч тэтгэвэрт гарсан бол уг ажлыг гүйцэтгэх үедээ ажиллаж байсан буюу толгойлогч байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудсыг ашиглана. Нэр дэвшүүлснээс хойш зохиогчийн танилцуулгад өөрчлөлт (ажил, албан тушаал, хаяг, утас) орсон бол энэ тухай Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд мэдэгдэнэ.

4.1.6. Бүтээлийн хоёр хувь үйлдсэн дэлгэрэнгүй тайлбар-танилцуулга. Танилцуулгад ажлын үндсэн агуулга, үр дүн, эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, үр дүнг хэрэглэсэн байдал, цаашид ашиглагдах хэтийн төлөв, шинжлэх ухаан, технологийн болон техник-эдийн засгийн үзүүлэлтүүдийг тусгана. Уг ажлыг улсын захиалгатай төсөл, хөтөлбөр, сэдэвт ажлын хүрээнд хэрэгжүүлсэн бол энэ тухай дурдана. Бүтээлийн дэлгэрэнгүй тайлбар-танилцуулгад шинэ технологи, техник, багаж, тоног төхөөрөмж, материал, бодисын үндсэн үзүүлэлт, ашиглалтын нөхцөлийг нээн харуулахаас гадна эх орны болон гадаадын ижил төрлийн бүтээлүүдтэй харьцуулсан дүгнэлт гаргаж, бүтээлийн үнэт чанарыг тусгасан байна. Шаардлагатай зураг, загвар, бүдүүвч зэрэг материалыг хавсаргаж, энэ ажлын хүрээнд нийтлүүлсэн бүтээлийн жагсаалт, авсан патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ, байгууллага, эрдэмтдээс өгсөн дүгнэлт, санал, шүүмжийг оруулна. Тайлбар-танилцуулгыг "Arial Mon"- 12-ын стандартгаар 1.5 интервалаар А4-ийн цаасан дээр бичсэн байна.

4.1.7. Шагналд нэр дэвшүүлсэн бүтээлийн товчоон. Товчоон нь А4 цаасан дээр

бичсэн 10 хуудаснаас хэтрэхгүй байна. Товчооныг 5 хувь үйлдэж, тус бүрийг эмхтгэл хэлбэрээр бэлтгэнэ. Товчоонд ажлын товч агуулга, шинжлэх ухаан, практикийн үндсэн ололт, үр дүнг ашигласан хүрээ, эдийн засгийн үр ашиг, шинэлэг байдлын үнэлгээ, ижил төрлийн бүтээлтэй харьцуулсан дүн зэргийг тусгана. Товчооны эцсийн хуудсанд дүн зохиогчдын овог, нэрийг нэг баганад дэлгэрэнгүй бичиж гарын үсэг зуруулсан байна.

4.1.8. Хураангуй. Хураангуй нь 1 хуудас байна. Түүний нэг талд шагналд нэр дэвшүүлж байгаа бүтээлийн нэр, байгууллагын нэр, зохиогчдын овог, нэр, ажлын газар, эрхэлж байгаа ажил, албан тушаал, эрдмийн зэрэг, цолыг бичих бөгөөд удирдагчийг эхэнд нь бичиж тэмдэглэгээ хийнэ. Цаасны нөгөө талд бүтээлийн товч агуулга, түүний шинжлэх ухаан, технологийн үндсэн санаа, үр дүн, ач холбогдол, эдийн засаг, нийгмийн өгөөжийн талаар бичнэ.

4.1.9. Нэмэлт материал. Нэмэлт материалыг нэр дэвшигч үзэмжээрээ бэлтгэх бөгөөд түүнд техникийн зураг, бүдүүвч, зохиогчийн эрхийн гэрчилгээний хуулбар, гэрэл зураг, сонин, сэтгүүлийн хайчилбар зэрэг байж болно. Энэхүү нэмэлт материалыг тусад нь хавсаргана.

4.2. "Технологийн дэвшлийн шагнал"-д байгууллагыг дэвшүүлэх тохиолдолд энэ журмын 4.1.4, 4.1.5-д зааснаас бусад материал, баримт бичгийг энэхүү журмын шаардлагад нийцүүлэн бүрдүүлнэ.

4.3. "Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагнал"-д гадаадын иргэн, байгууллагыг дэвшүүлэхдээ дор дурдсан материал бүрдүүлнэ:

4.3.1. шагналд нэр дэвшүүлэх тухай албан бичиг. Уг албан бичигт шагналд дэвшүүлэх болсон үндэслэлийг товч тодорхойлж, холбогдох баримт материалаар нотолсон байна;

4.3.2. шагналд нэр дэвшүүлж байгаа байгууллагын хамт олны хурлын тэмдэглэл;

4.3.3. шагналд нэрийг нь дэвшүүлж байгаа гадаадын иргэн, байгууллагын тухай танилцуулга. Танилцуулгад аль улсын ямар байгууллага (иргэн) болох, үйл ажиллагааны чиглэл, манай улсын холбогдох байгууллагатай хамтран ажилласан туршлага, байгууллага (иргэн)-ын шуудангийн болон интернетийн хаяг, вэб сайтыг тусгасан байна;

4.3.4. шагналд нэр дэвшиж байгаа байгууллага (иргэн)-аас манай улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг энэ журмын 2.3-т заасан шаардлагын дагуу гаргасан дэлгэрэнгүй танилцуулга. Танилцуулгад тухайн байгууллага, иргэнээс манай улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээ, эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн бодит үр дүн, өгөөжийг баримт материалаар нотлон харуулсан байхаас гадна уг үйл ажиллагааны үр

дүнг хүртэгч монголын талын байгууллагуудын санал, үнэлгээ, дүгнэлтийг тусгасан байна.

4.4. Бүрдүүлсэн материалд байгаа бүтээлийн нэр, байгууллагын нэр, зохиогчдын овог, нэр, ажлын газар, эрхэлж байгаа ажил, албан тушаал зөрүүгүй байна.

4.5. Шагналд нэр дэвшүүлсэн материалыг энэ журмын 4.1.1-4.1.9-д заасан дарааллаар байрлуулна.

4.6. Бүрдүүлсэн материал нь монгол хэл дээр байх бөгөөд товчилсон үг хэрэглэхгүй, гадаад хэл дээр хэвлэгдсэн материалыг хавсаргах бол орчуулан нотариатаар баталгаажуулсан байна.

4.7. Нууцын зэрэглэлтэй бүтээлийг нэр дэвшүүлж байгаа бол бүрдүүлсэн материалд нууцын тэмдэг дарсан байна.

Тав. Бүтээлийг хүлээн авах, шалгаруулах

5.1. Шинжлэх ухаан, технологийн салбарын шагналд нэр дэвшүүлж, энэ журамд заасан шаардлагын дагуу бүрдүүлсэн материал, баримт бичгийг зохиогч болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд энэ журмын 3.11-д заасан хугацаанд хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

5.2. Бүрдүүлэлт дутуу материалыг хүлээн авахгүй. Үнэлгээнд оруулсан материал, баримт бичгийг зохиогчдоод буцаан олгохгүй, зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

5.3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас шинжээчийн дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн бүтээлийн жагсаалтыг шагнал олгох өдрөөс 3 сараас доошгүй хугацааны өмнө зохиогчийн нэрийн хамт хэвлэлд нийтэлж, олон нийт, мэргэжлийн байгууллага, хүмүүсийн саналыг авна. Санал өгөх этгээд нь овог, нэр, эрхэлж байгаа ажил, албан тушаал, байгууллага, гэрийн хаяг, утасны дугаарыг гаргачтай бичиж ирүүлнэ. Нэр, хаяг тодорхойгүй буюу журамд заасан шаардлага хангаагүй саналыг хүлээн авахгүй.

5.4. Дэвшүүлсэн бүтээлд шинжээчийн дүгнэлт гаргаж шалгаруулах, шагнал олгох санал бэлтгэх ажлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам дор дурдсан журмаар зохион байгуулна:

5.4.1. шагналд дэвшүүлсэн материалыг хүлээн авч энэ журмын шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах;

5.4.2. шаардлага хангасан бүтээлд шинжээчийн дүгнэлт гаргах үүрэг бүхий холбогдох эрдэмтэн, мэргэжилтний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг сайдын тушаалаар томилно;

5.4.3. энэхүү журмын 5.4.2-т заасан шинжээчийн дүгнэлтийг төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл бүхий комиссын хурлаар хэлэлцүүлэн шагнал олгохоор дэвшүүлэх бүтээлийг сонгоно. Сонгосон бүтээлийн талаархи материалыг тухайн жилийн 10 дугаар сард багтаан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ. Шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг нэр дэвшсэн бүтээлийн хамаарах салбарыг харгалзан шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухай бүр томилно.

5.5. Энэ журмын 2-т заасан шаардлага хангасан бүтээл гараагүй тохиолдолд журмын 1.2-т заасан шагналуудыг олгохгүй.

Зургаа. Шалгарсан бүтээлийг баталгаажуулах, шагнал олгох

6.1. Шинжлэх ухаан, технологийн салбарын шагналыг Монгол Улсын шинжлэх ухааны ажилтны өдрөөр олгоно.

6.2. Шагналыг Монгол Улсын Ерөнхий сайд ёслол хүндэтгэлтэй гардуулна.

6.3. Шагналын үнэмлэхэд Монгол Улсын Ерөнхий сайд гарын үсэг зурна.

6.4. Шагналыг дагалдах мөнгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохиогчийн багийн гишүүдэд тэнцүү хуваарилж олгоно. Нас барсан хүний шагналыг хууль ёсны өв залгамжлагчид нь зохих хууль тогтоомжид нийцүүлэн олгоно.

6.5. "Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагнал"-ыг гардан авах нэг хүний тухайн орноос Улаанбаатарт ирэх, буцах онгоцны билет, Улаанбаатарт 3 хоног байх зочид буудал, хоолны зардлыг Монголын тал хариуцана.

6.6. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь шагнал хүртэгчдийн мэдээллийн санг бүрдүүлнэ.

Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох журмын 1 дүгээр хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ АЛБАН БИЧГИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

1. Шинжлэх ухаан, технологийн шагналд нэр дэвшүүлэх албан бичгийг уг шагналд нэр дэвшүүлж байгаа байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр дор дурдсан загвараар 2 хувь үйлдэнэ:
"_____байгууллагын эрдмийн зөвлөл (хамт олон)

(байгууллагын бүтэн нэр)

шинжлэх ухаан, технологийн салбарын 200. ____оны шагналд"

(ажлын нэр, түүний агуулгыг маш товч, оновчтой тусгана)

ажлыг дэвшүүлж байна. Энэ ажлын зохиогчдын хамтлагийн гишүүд нь:

1. _____

(Зохиогчийн овог, нэр, эрдмийн зэрэг, цол, ажилладаг байгууллага, албан тушаал)

2. _____

3. _____ (гэх мэт) нар болно.

2. Нэр дэвшүүлэх албан бичигт зохиогчдын нэрсийг цагаан толгойн үсгийн дарааллаар бичих бөгөөд удирдагчийг нэрсийн жагсаалтын эхэн дээр "бүтээлийн удирдагч" гэсэн тодотголтойгоор бичнэ.

3. Шагналд нэр дэвшүүлж байгаа бүтээлийн зохиогч өндөр насны тэтгэвэрт гарсан бол түүний сүүлд ажиллаж байсан байгууллага, эрхэлж байсан албан тушаалыг бичнэ.

4. Нэр дэвшүүлэх албан бичигт дор дурдсан зүйлийг тусгасан байна:

- Бүтээлийн товч агуулга;
- Шагналд дэвшүүлэх болсон үндэслэл;
- Бүтээлийг боловсруулж (туурвиж) эхэлсэн болон дууссан хугацаа, үр дүнг нь практикт хэрэгжүүлсэн үе.

5. Шагналд нэр дэвшүүлэх албан бичгийг уг бүтээлийг дэвшүүлэгч байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр үйлдэж, тухайн байгууллагын дарга (захирал) гарын үсэг зурж баталгаажуулна.

**Шинжлэх ухаан, технологийн салбарын
шагнал олгох журмын 2 дугаар хавсралт**

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГЫН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ (ХАМТ ОЛОН)-ИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Шинжлэх ухаан, технологийн шагналд нэр дэвшүүлсэн байгууллагын эрдмийн зөвлөл (хамт олон)-ийн хурлын тэмдэглэлийг дараахь загвараар 2 хувь үйлдэнэ.

* _____ "БАЙГУУЛЛАГЫН ЭРДМИЙН
(байгууллагын бүтэн нэр)
ЗӨВЛӨЛ (ХАМТ ОЛОН)-ИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

 200. оны. дугаар
сарын...ны өдөр

Дугаар

 Улаанбаатар
хот

Зөвлөлийн бүрэлдэхүүн _____ хүн

Хуралд оролцсон _____ хүн

Шинжлэх ухаан, технологийн 200. оны шагналд нэр дэвшүүлэх " _____ (ажлын нэр)

_____ " бүтээл болон түүний зохиогчдын бүрэлдэхүүний тухай сонсов.

Хэлэлцэж байгаа асуудлаар _____ нар үг хэлж, санал гаргав (Хүмүүсийн хэлсэн үг, гаргасан саналыг бичнэ).

Бүтээлийг шагналд нэр дэвшүүлэх болон түүний зохиогчийн бүрэлдэхүүнийг тогтоох талаар нууц санал хураалт явуулав. Нууц санал хураалтад _____ хүн оролцов. Нууц санал хураалтын дүнг үндэслэн:

1. " _____ " бүтээлийг шинжлэх

(бүтээлийн нэр)

ухаан, технологийн салбарын 200. оны шагналд нэр дэвшүүлэв.

Нууц санал хураалтын дүнгээр уг бүтээлийг шагналд нэр дэвшүүлэх саналыг дэмжсэн _____, дэмжээгүй _____, хүчингүй хуудас _____, санал хураалтын хувь _____

2. Шинжлэх ухаан, технологийн 200. оны шагналд нэр дэвшүүлж байгаа энэхүү бүтээлийн зохиогчийн багийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар тогтов:

№	Овог, нэр, эрдмийн зэрэг, цол	Ажлын газар, албан тушаал	Санал хураалтын дүн		
			Дэмжсэн	Дэмжээгүй	Хүчингүй хуудас
1					
2					
3					
4					
5					

Эрдмийн зөвлөл (хамт олон)-ийн дарга _____
 Эрдэмтэн нарийн бичгийн дарга _____

Тайлбар: Энэхүү тэмдэглэлд тухайн байгууллагын тамга дарж баталгаажуулсан байна. Хэрэв зохиогчийн багийн бүрэлдэхүүнд өөр байгууллагын хүн орж байгаа бол түүний ажилладаг үндсэн байгууллага нь түүнийг дээрх маягаар дэвшүүлж баримт бичгийг бүрдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.2-ыг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг хавсралтын ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж түүнд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөө тусгаж байхыг Эрүүл мэндийн сайд Д.Туяа, Сангийн сайд Н.Баяртсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн IY улиралд Засгийн гээрт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд Д.Туяад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
 ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Д.ТУЯА

Засгийн газрын 2007 оны 150 дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Төв Азийн өргөн уудам нутагт монголчууд олон мянган жил амьдрахдаа байгаль, цаг улирал, ахуй нөхцөлдөө зохицсон биеийн тамир, спортын өвөрмөц төрөл, дасгалаар хичээллэн бие бялдар, хүч чадалаа хөгжүүлж, цэрэг, байлдааны бэлтгэлтэй эрүүл чийрэг, хүч чадалтай ард түмэн байсаар ирсэн.

Даяаршлын өнөө үед улс үндэстэн бүр уламжлагдан ирсэн үндэсний өвөрмөц спортын төрлийг хөгжүүлж, дэлхий нийтэд таниулахад анхаарч тодорхой бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Монгол Улсын төр, засгаас үндэсний спортыг хөгжүүлэхэд анхаарч Үндэсний их баяр наадам болон үндэсний спортын их наадмыг зохион байгуулсны үр дүнд энэ спортоор хүн амын 12.7 хувь нь хичээллэж, үндэсний спортын холбоодын үйл ажиллагаа идэвхжин, үндэсний спортын уралдаан тэмцээнд оролцож байгаа гадаад, дотоодын тамирчид болон сонирхогчдын тоо нэмэгдэх хандлагатай байна.

Уламжлагдан хөгжиж ирсэн үндэсний спорт, тоглоом наадгай, шинээр хөгжиж байгаа спорт нь монгол хүний ёс суртахуун, гоо зүй, зан үйлийн олон сайхан өв уламжлалыг шингээсэн хурд хүч, хүрц хараа, хүч чармайлт, эв дүй, оюун ухаан, сэтгэн бодох чадварыг хөгжүүлж, бие бялдарын боловсрол соёлыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Иймээс үндэсний спортоор дамжуулан хүн амын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, ажиллах чадварыг дээшлүүлэн хувь хүний хөгжлийг хангахад иргэд, байгууллага, хамт олноос гарсан санаачилга, хүчин чармайлтыг дэмжин өргөжүүлэх, орон нутгийн биеийн тамир, спортын байгууллага болон үндэсний спортын холбоодын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах, нөөц бололцоог зөв ашиглахад нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган хөгжүүлэх шаардлага бий болж байгаа юм.

Үндэсний спортыг зах зээлийн үед хүн амын эрүүл мэндийг сайжруулах, төрийн бус байгууллагын оролцоог дэмжих замаар хөгжүүлэх зорилгоор Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэнэ)-ийг боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, хугацаа, зарчим, санхүүжилт

2.1. Монголчуудын уламжлалт болон шинээр хөгжиж байгаа үндэсний спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололт, уламжлалд тулгуурлан хөгжүүлэх, өсвөр үеийнхэнд өвлүүлэх, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, бусад улс оронд сурталчлахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийг 2007-2012 онд хэрэгжүүлэх бөгөөд, дунд хугацааны үнэлгээг 2010 онд хийнэ.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална.

2.3.1. үндэсний спортыг хөгжүүлэх үйл ажиллагаа нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хамтын ажиллагаанд тулгуурлана;

2.3.2. уламжлагдан хөгжиж ирсэн үндэсний спортын төрөл (хурдан морь, бөхийн барилдаан, сурын харваа, жороо морь, шагайн харваа, уран уургач, бугуйлч, эмнэг булгиулалт)-ийг бүсчилэн хөгжүүлнэ;

2.3.3. үндэсний спортыг хөгжүүлэх үйл явц тасралтгүй залгамж шинжтэй байна.

2.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

2.4.1. улсын болон орон нутгийн төсөв;

2.4.2. эрүүл мэндийг дэмжих сангаас олгох хөрөнгө;

2.4.3. гадаад дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

2.4.4. олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж, хандив;

2.4.5. бусад эх үүсвэр.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.1. Зорилт 1. Үндэсний спортыг хүн амын дунд хөгжих таатай орчин бүрдүүлж, материаллаг баазыг бэхжүүлнэ:

3.1.1. аймаг, сум бүрт үндэсний спортын байр, талбайг орчин үеийн зориулалтаар тохижуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

3.1.2. ерөнхий боловсролын сургууль болон амралт, хүүхдийн зусланг түшиглэн үндэсний спортын секц, дугуйланг тухайн спортын холбоодын оролцоотойгоор ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;

3.1.3. хугацаат цэргийн албан хаагчдад үндэсний спортын талаархи мэдлэг олгох дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;

3.1.4. төв, орон нутгийн "Олимп" сургалтын төвийг түшиглэн "Үндэсний спортын булан" байгуулж үндэсний спортоор хичээллэгчид болон хүн амд зориулж үндэсний спортын талаар сургалт, сурталчилгаа хийх;

3.1.5. үндэсний спортын холбоод, төрийн бус болон хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо, дэмжлэгтэйгээр үндэсний спортын талаархи сурталчилгааг сайжруулах;

3.1.6. үндэсний спортын хэрэглэл хэрэглэгдэхүүн нийлүүлэх, тоног төхөөрөмж үйлдвэрлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс гаргасан санал санаачилгыг дэмжих.

Хүрэх үр дүн:

-үндэсний спортын төрөл хөгжих таатай орчин бүрдэж, уралдаан тэмцээнийн зохион байгуулалт сайжирна;

-үндэсний спортын хэрэглэгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрийн тоо

нэмэгдэж, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон үндэсний спортын тоног төхөөрөмж, хэрэглэлээр хангагдана.

3.2. Зорилт 2. Үндэсний спортын уламжлалт заншил, зан үйлийг сэргээн сонирхогчдын хүрээг өргөжүүлнэ:

3.2.1. үндэсний спортын төрлийг спортын шинжлэх ухааны түвшинд судлан (түүх, удам, голомт, нутаг, биологи, анатоми, физиологи, морфологи, генетик, сэтгэл зүй, техник тактик, арга мэх, туршлага, үүлдэр угсаа, уяа сойлго г.м) хөгжүүлэх;

3.2.2. үндэсний спортын соёл, зан үйл, техник, арга барилын талаар сургалт, сурталчилгааны материал, гарын авлага, VCD, DVD бичлэг хийж түгээх;

3.2.3. Үндэсний их баяр наадам, Цагаан сар, Ахмадын өдрөөр ахмад болон залуу үеийнхнийг оролцуулан үндэсний спортын танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлж байх;

3.2.4. шинээр хөгжиж байгаа үндэсний спортын зарим төрлийг орон нутаг болон үндэсний хэмжээнд өвөрмөц сонирхолтой хэлбэрээр сурталчлах;

3.2.5. үндэсний спортын арга зүйн, багш, дасгалжуулагч, шүүгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авах.

Хүрэх үр дүн:

-үндэсний спортоор хичээллэгчдийн тоо нэмэгдэж, үндэсний спортын уламжлалт зан үйл, соёлын талаархи иргэдийн мэдлэг, хандлага сайжирна;

-шинээр хөгжиж байгаа үндэсний спортын зарим төрөл төв болон орон нутагт жигд хөгжих нөхцөл бүрдэнэ.

3.3. Зорилт 3. Үндэсний спортын төрлийг монгол туургатан, гадаад оронд түгээн дэлгэрүүлнэ:

3.3.1. үндэсний спортын төрлийг монгол туургатан, гадаад оронд сурталчлах зорилгоор сурталчилгааны материал, гарын авлага, VCD, DVD бичлэг гаргах;

3.3.2. гадаад оронд монгол үндэсний спортоор хичээллэгч, сонирхогчдыг зарим хэрэгсэл, материалаар хангах асуудлыг судлан шийдвэрлэх;

3.3.3. Монгол Улсаас гадаад оронд суугаа Дипломат төлөөлөгчдийн газрыг үндэсний спортын талаархи сурталчилгааны материал, мэдээллээр хангах;

3.3.4. орон нутгийн түвшинд хөгжсөн үндэсний өвөрмөц спортын төрлөөр аялал жуулчлалын арга хэмжээний хүрээнд бэсрэг наадам зохион байгуулах;

3.3.5. үндэсний спортын асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хурал, уулзалт, зөвлөлгөөн зохион байгуулах.

Хүрэх үр дүн:

-гадаад орнуудад монголын үндэсний спортыг сурталчлах сурталчилгаа сайжирсан байна;
 -үндэсний спортын асуудлаар монгол судлаачдын бүтээл нэмэгдсэн байна;

-үндэсний спортоор хичээллэгч, сонирхогч улс орон, жуулчдын тоо нэмэгдэнэ.

3.4. Зорилт 4. Үндэсний спортын асуудлаар эрх зүйн таатай орчин бүрдүүлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно.

3.4.1. биеийн тамир, спортын талаархи хууль тогтоомжид үндэсний спортын цаашдын хөгжлийн чиг хандлагад нийцсэн нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.4.2. үндэсний спортын холбоодын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлэлт өгөх асуудлыг судлан шийдвэрлэх;

3.4.3. үндэсний спортын төрлүүд, ялангуяа хурдан морины уралдаан, түүнд оролцогчдын хамгаалалт, аюулгүй байдал болон орчны стандартыг боловсруулан мөрдүүлэх;

3.4.4. үндэсний спортын холбоодыг магадлан итгэмжлэх замаар үйл ажиллагаанд нь хяналт тавьж биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр улсын болон бүсчилсэн уралдаан тэмцээнийг зохион байгуулах эрх олгож байх;

3.4.5. үндэсний спортыг хөгжүүлэх асуудлаар биеийн тамир, спортын бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий үндэсний спортын асуудал хариуцсан нэгжийг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын орон тоо, бүтцэд багтаан ажиллуулах;

3.4.6. үндэсний спортын чиглэлээр ажиллаж байгаа ажилтан, багш, арга зүйч, дасгалжуулагч нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээ авах;

3.4.7. бүх шатны Засаг дарга нар үйл ажиллагааны хөтөлбөртөө үндэсний спортыг хөгжүүлэх асуудлыг тусган хэрэгжүүлэх.

Хүрэх үр дүн:

-үндэсний спорт хөгжих эрх зүйн таатай орчин бүрдэнэ;

-үндэсний спортын холбоодын үйл ажиллагаа идэвхжинэ.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, салбар дундын оролцоо, хамтын ажиллагааг зохицуулах асуудлыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

4.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хяналт-шинжилгээ хийх, мэдээллээр хангах, үр дүнг тооцох асуудлыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

4.3. Орон нутгийн хэмжээнд бүх шатны Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороод хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үндэсний спортын салбар холбоодтой хамтран хөтөлбөрийн биелэлтийг тайлагнан ажиллана.

4.4. Үндэсний спортын хөтөлбөрийн үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог хангах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хэрэгжүүлэх асуудлыг биеийн тамир, спортын бүх шатны байгууллага хариуцна.

4.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Одоогийн түвшин 2006	Хүрэх үзүүлэлт	
			2010	2012
1.	Үндэсний спортоор хичээллэгчдийн хувь	12.7	14	17
2.	Сурах бичиг, гарын авлага, сургалтын товхимолтой болсон спортын төрлийн тоо	4	8	10
3.	Үндэсний спортын төрлөөр мэдлэг, мэргэшлийг дээшлүүлсэн багш, арга зүйчдийн тоо	378	756	900
4.	Үндэсний уламжлалт спортын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр долоо хоногт нэвтрүүлсэн цагийн тоо	0	8	12
5.	Шинэ танхим, талбайтай болсон үндэсний спортын төрлийн тоо	4	6	10
6.	Үндэсний спортын төрлийн ордон, байр, талбайн тоо	4	5	8
7.	Үндэсний спортын талаар нийтээр дагаж мөрдөх стандартын тоо	0	5	10

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав
 Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
 Хэвлэх хэсэгт хэвлэв

Улаанбаатар-12
 Төрийн ордон

☎ 265958
 Индекс: 14003

☎ 329487

Хэвлэмийн хуудас 2/5